



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

**Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалт, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 54,450,000.00 (тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа С.Пүрэвсамдан, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 13 өдрийн
100 дугаар тогтоолын хавсралт

Дархан-Уул аймгийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Дархан-Уул аймгийн
Онцгой байдлын газарт эзэмшүүлж, бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	"Уаз фургон" арлын дугаар ХТТ374195М1210261, улсын дугаар 01-08 ДАУ	2020/2021	1	36,500,000.00	36,500,000.00
2	"Соната-8" арлын дугаар КМНЕ341DBGA167971, улсын дугаар 88-19 ДАА	2015/2020	1	17,950,000.00	17,950,000.00
	Нийт дүн		2		54,450,000.00 (тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин мянга)